

Төрийг урлахуй



М.Энхсайхан

ТӨРИЙГ УРЛАХУЙ

- ОРЧИН ҮЕИЙН ТӨРИЙН ҮҮСЭЛ, ГАРАЛЫН ТУХАЙ
- ТӨРИЙГ ШИНЭЭР ЗОХИОХ ДЭЛХИЙН ӨРСӨЛДӨӨН
- МОНГОЛ ТӨРИЙГ УРЛАХ АСУУДАЛД

Энэ лекцийг Бил Гэйтсийн хэлсэн үгээр эхэлмээр санагдаж байна. Тэрбээр “Ном унших дадал бол Харвардын дипломоос чухал” гэжээ. Харвард орчин үеийн төрийн мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх том сургууль юм. Диплом нь оюуны оройд гарсан хэрэг биш, сэтгэлгээгээ хөгжүүлэхийн чухлыг Бил Гэйтс хэлсэн бизээ.

Миний лекц “Төр” гэдгийн тухай сүүлийн 400 жилд гарсан хамгийн од болсон, онолын суурь дэвсгэр болсон номын тухай юм. “Төр” хэмээх улс төр, нийгмийн зохион байгуулалт хэрхэн бий болсон, төрийн мөн чанарын өөрчлөлтийг цаг хугацааны хувьд нь олон зуун жилд нь хэлхэж ойлгож авах явдал дэлхий ертөнц, олон улсын харилцааг углуургаар нь ойлгож авахад нэн чухал ач холбогдолтой юм.

ПРЕЗЕНТАЦИЙН ЗОРИЛГО

- Том сэдэв, Чухал сэдэв. Барууны эрдэмтэдийн энэ талаарх үзэл бодлыг нэгтгэж ойлгоход туслах
- Орчин үеийн “Монгол төр”-ийн түүхийг тольдох өнцгийг тодорхой болгох
- “Монгол төр”-ийг урлах прагматик байр суурийг тодорхойлоход туслах

Презентаци танилцуулгын зорилго нь Төр хэмээх том институци тогтолцоог тойрсон асуудлыг арай өргөн харах бололцоог хүн бүрт бий болгох гэсэн явдал юм. Тухайлбал, Төрийн тухай барууны эрдэмтэдийн энэ талаарх үзэл бодлыг нэгтгэж ойлгоход туслах, Орчин үеийн “Монгол төр”-ийн түүхийг тольдох өнцгийг тодорхой болгох, “Монгол төр”-ийг урлах прагматик байр суурийг тодорхойлоход туслах зорилготой юм.

ТӨРИЙН ТУХАЙ




- Шинжлэх ухаанд, олон улсын эрх зүйд Төр гэдгийг нэг мөр ойлгох тодорхойлолт байхгүй
- Монтевидео Конвенци (1933)
 - Хүн ам
 - Газар нутаг
 - Өөрийн засаг төр
 - Бусадтай харилцаанд орох чадамж (Бусдаар хүлээн зөвшөөрүүлэх шаардлага байхгүй)
- Төрийн тухай зарим тодорхойлолт
 - Ноёлогч ангийн хүчирхийллийн хэрэгсэл
 - Бюрократуудын хувийн өмч
 - Хууль эрх зүй тогтоогч
 - Диваажинд хүргэх хэрэгсэл биш, амьдрал Там болохоос сэргийлэх хэрэгсэл

Төр гэдгийг хамгийн дөт ойлгоход Пан Америкийн орнуудын хооронд байгуулсан Монтевидеогийн Конвенц тус болж магадгүй. Дөрвөн том шинж тэмдэг дээр тулгуурлажээ. Хүн ам, газар нутаг, өөрийн засаг төр, бусадтай харилцаанд орох чадамж. Монголын түүхэнд холбогдуулж ойлговол Их Монгол улсын түүхийг орчин цагийн Төр хэмээх ойлголтод хамруулахад энэ шинж тэмдэгүүд учир дутагдалтай байж мэдэхээр. Гэвч Их Монгол улсын олон асуудал өнөөгийн Төр хэмээх ойлголтуудын олон элементийг дотроо багтаасан болов уу гэж бодож байгаа юм. Хатуу зохион байгуулалт, сахилга дэг журам, өртөө алба, өнчдын авилга гээд олон зүйлийг ярьж болно. Гэвч энэ тухай ярих нь өнөөдрийн сэдэв биш юм.



Өнөөгийн ертөнцөд тогтсон орчин үеийн Төрийн үүсэл, төрлийг 3 ангилалд оруулж ойлгож байна. Орчин үеийн төрийн анхдагч нь Үндэстэн төр байсан бол тэр нь Либерал төр болж, удаах нь Халамжийн төр юм. Өөр хоорондоо уялдаатай. Нэг нь нөгөөгөөсөө урган гарсан байна. Гол нь Төр амьд организм. Өсдөг, томордог, бойждог, хөгждөг, унадаг амьд организм. Хөгжлийн дотоод эх шалтгаантай. Хэн нэгний хүсэл зоригоос үл хамаарна гэж ойлгож авах нь ихэд чухал санагдаж байна.

2014 онд нэгэн ном гарсан нь Барууны судалгаа шинжилгээний томоохон институтэд өргөнөөр хэлэлцэгдэж байгаа юм.



Thomas Hobbes. 1651

Homos homini lupus est
(Хүн хүндээ чоно)
Bellum omnium contra omne
(Бүгдийн эсрэг бүгд дайт)

- Иргэний болон Шашин хоорондын дайныг хазаарласан.
- Үндэстэн төрүүд өөрсдийгөө шашнаас тусгаарлаж чадсан эсэхээр өрсөлдөж байв.

Үндэстэн-төр. Томас Хоббс асуудалд хандахдаа хүн бол байгалиас өгсөн өгөгдөхүүнээрээ амьтан гэж үзэж байна. Тиймээс хүний нийгэмд “хүн хүндээ чоно” гэсэн зарчим үйлчилнэ гэж тэрбээр үзэж байна. Манай дээдэс хүний хөгжилд “хижи гөрөөс”, “хүн-адгуус”-ийн үе байсан тухай дурдсан байдаг. Ижилхэн сонсогдож байгаа биз?

ҮНДЭСТЭН-ТӨР – LEVIATHAN - МАНГАС ?




Т. Хоббс “ХҮН өөрөө үргэлж өөр хоорондоо тэмцэлддэг тул үүнийг **“Нийгмийн гэрээ”** буюу хуулиар л зохицуулж, нэг нь нэгэндээ захирагдах боломжтой гэж үзсэн.

Хүн хүндээ чоно байх нөхцөлд тэд энэ эрх чөлөөгөө эдэлбэл хүмүүн бие биеэ устгана. Тиймээс “Бусдын эсрэг бүгд дайтах” нь гарцаагүй юм. Хүмүүн бие биеэ утсгаад байж болохгүйн тулд тэдний энэ байдлыг Хэн нэг нь зогсоодог байх хэрэгтэй болно. Хүнийг чоно гэж үзэж байгаа тулд Тэрхүү хэн нэг нь хүн биш байх хэрэгтэй болсон. Иймээс Хоббс тэрхүү хэн нэгийг Лефифан гэж нэрийджээ. Монголчилбол “Мангас” хэмээж болох юм. Эндээс Төр хэмээх ойлголт эхлэх бөгөөд Төрийг мангасчлах санаа ч мөн энэ үеэс эхлэлтэй байж болох юм.

Хүн өөр хоорондоо дайтахгүйн тулд “Нийгмийн гэрээ” хэрэгтэй гэж. Тэр нь яваандаа хууль эрх зүй үүсэхтэй холбоотой юм. Хүн өөрөө өөрийгөө хуулийн хүрээнд дарангуйлахыг зөвшөөрснөөр Үндэстэн-төрийн эхлэл тавигдсан байна.

Европын анхны үндэстэн-төрүүд шашин хоорондын мөргөлдөөнийг хазаарлаж, тэр ч байтугай хэн нь шашнаас өөрийгөө тусгаарлаж чадсан бэ гэдгээр уралдаж байсан нь сонин юм. Тэр үеэс Төр, шашиныг зааглах зарчим улс төрийн зарчим болж хөгжиж эхэлсэн байна.




Сэргэн мандалт
Франц, Америк, Британы хөрөнгөтний хувьсгал
Аж үйлдвэрийн хувьсгал



Илүү бүтээмж дээр суурилсан хариуцлагатай
төрийг бий болгохыг зорьсон.

Хүн төрөлхтний хөгжил дараачийн шат руугаа орлоо. Төр аюулгүй байдлыг хангах эхний үүргээ биелүүллээ. Удаах үед эрх чөлөөг хамгаалах асуудал чухалчлагдав. Энэ нь Либерал төрийн үндэс болсон байна.

Либерал төр бол нэлээд хувьсгалт үзэл санаа байсан. Том төр эрх чөлөөнд дайсагнах аюултай байгааг харжээ. Дээр нь Аж үйлдвэрийн хувьсгал материаллаг баялгийг урд өмнөх хэмжээнээс хавьгүй их болгож чадсан нь чөлөөт худалдааг номлох бололцоог бий болгосон байна. Төрийн эдийн засгийн хүч чадал урд өмнөхөөс эрс нэмэгдсэн нь гарцаагүй юм. Төрд бүхэл бүтэн аристократ давхрага бий болсон. Тэд эрх чөлөөг хүсэмжлэх хэрнээ материаллаг баялагийг илүү ихээр бүтээхийг сонирхох болсон нь гарцаагүй байх.



1848

- ЧӨЛӨӨТ ХУДАЛДАА
- ЖИЖИГ ЗАСГИЙН ГАЗАР

Radical views

(Radix) Root -Үндэс, язгуур,
хувьсгалт,

WELFARE STATE БУЮУ ХАЛАМЖИЙН ТӨР 19-20 ДУГААР ЗУУН



Beatrice Webb

Cooperative Movement in Great Britain (1891)



▪ Хүүхдийн өдрийн хоол	1906
▪ Тэтгэвэр	1908
▪ Ядуурлын эсрэг төсөв	1909
▪ Өвчтэй, ажилгүй хүмүүсийн даатгал	1911

- Боловсролгүй, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжгүй ажилчинд эрх чөлөө байгаад яах вэ?
- Сонгуульд санал өгөх эрхтэй байгаад юунд хүргэх вэ?
- Дээрээс нь улс орнууд чадалтай, боловсролтой ажиллах хүчээрээ өрсөлдөх шаардлагатай

Бараг 20 дугаар зуун хүрч байж Либерал Төр нь Халамжийн Төр болох тал руугаа алхаж эхэлжээ. Биатрес Уэб гэдэг нэгэн англи эмэгтэйн “Хамтралын хөдөлгөөн”, “Нэгдэлжих хөдөлгөөн” ч гэж орчуулж болох бяцхан ном хэвлэгдлээ. Зөрүүтэй бүх санал бодол, улс төр хамтарч нэгдэлжиж болох тухай асуудал хөндөгдөв. Энэ нь өнөөгийн орчин үеийн Халамжийн төрийн онолын үндэс байсан гэх болжээ.

ХАЛАМЖИЙН ТӨР. М.ФРИДМАНЫ ХАГАС ХУВЬСГАЛ



Milton Friedman


ТОМ ТӨР ЭДИЙН ЗАСАГТ ЗАНАЛХИЙЛСЭН



АНУ-ын 20-р зууны хамгийн нөлөө бүхий Эдийн засагч гэгдэх түүний нөлөөгөөр Рональд Рейган, Маргарет Тэтчер нар Төрийн зардлыг багасгах, хувьчлалыг идэвхитэй явуулах арга хэмжээнүүдийг авч байсан.

Халамжийн Төр өнөөгийн дэлхий ертөнцийн төрийн хэв загварыг тодорхойлж байна. Хүн амын өсөлт, хүн амын насжилт боловсрол, тэтгэвэрт зарцуулах Төрийн зардлыг нэмэгдүүлэх бодит нөхцөл болов. Дээр нь баруун, зүүнээр ялгарсан улс төрчид төрийн зардлыг нэмэгдүүлэх өрсөлдөөнийг хурцатгаж байв. Капитализм, социализм гэж дэлхий ертөнц хуваагдсан байдал ч энэ байдлыг дэвэргэж байлаа. Халамжийн Төр томрох хэмжээгээр эдийн засгийн үр ашиг унаж Халамжийн Төр улам бүр эдийн засагтайгаа зөрчилд орж байв.

"ТОМ ЗГ" VS "ЖИЖИГ ЗГ"



Төр эдийн засгаа дарангуйлан томорч Том төр болох, Төр үүргээ гүйцэтгэж чадахгүй болтлоо жижигрэх нь адилхан аюултай юм. Тэр ч байтугай Дэлхийн хоёрдугаар дайныг Том төрүүдийн мөргөлдөөн гэж үзэж болохоор байгаа юм. Гэхдээ төр гэхээсээ илүүтэй тоталитари дэглэмүүд байсан гэж тайлбарлах хүмүүс бас байна.

ӨРСӨЛДӨӨН БА 4 ДЭХ ХУВЬСГАЛ: АРДЧИЛАЛ ӨӨРӨӨ АСУУДАЛ



Бүхэлд нь өнгөрсөн 400 жилийн Төрийн түүхийг эргэн харвал Төрийн үүсэл хөгжлийн логикийг ойлгож болно. Төр зогсонги эд биш, цаашид хөгжин боловсронгуй болгох эд гэдэг нь ойлгомжтой юм.

- СИНГАПУР
- НОРДИК. ХОЙТ ЕВРОПЫН УЛСУУД




Хэрхэн боловсронгуй болох ёстой вэ гэдэг асуудал өнөөгийн тулгамдсан асуудал болж байна. Капитализмыг хуулбарлахад Барууны орнууд үлгэр жишээ болж байсан бол Төрийг хуулбарлахад Дорнийн орнууд арай илүү үлгэр жишээ болж байгаа тухай яригдаж байна. Жишээ болгож Сингапурыг авах нь олонтаа байгаа.



Улс орон хөгжихөд
ардчиллаас илүү
сахилга бат чухал

- ЕБС-аас Шигшүүрчлэл
- ДНБ ба Бонус



Төрийг урлах асуудлаас улс орнуудын ирээдүй хамаарч байна. Төрийн албаны боловсон хүчний чадал чансааг дээшлүүлэх асуудал тэргүүн зэргийн ач холбогдолтой болж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ УДИРДАГЧДЫГ БЭЛТГЭХ



John F. Kennedy
School of Government



China Executive Leadership
Academy in Pudong (CELAP)

- Ирээдүйн төрийг авч явах удирдагчдыг бэлтгэдэг

• 'Ask what you can do' is a resonant theme that extends across Harvard and makes all of us so much more aware of what it means to have these responsibilities and how they might be exercised,

Хятад энэ тал дээр нэлээд үлгэрлэж байгаа. CELAP жилдээ 10 000 боловсон хүчин бэлтгэдэг. Энэ бол намын сургууль биш. Төрийн ирээдүйн удирдагчдыг бэлтгэх сургууль юм. Өргөст тороор хүрээлэгдсэн, Харуул хамгаалалттай энэ сургууль Хятадын ирээдүйн төрийн удирдагчдыг бэлтгэж байна. Энэ сургуулийг Харвардын сургуультай адилтгаж үзэх явдал бий. Ийм төрлийн сургуулийг Азийн олон оронд бий болгохыг зорьж байна. Зорилго нь Төрийг урлах явдал юм.

ДЭЛХИЙН ӨРСӨЛДӨӨН БА МОНГОЛ

■ Том гүрнүүд

- Цэргийн давамгай байдлын төлөө
- Эдийн засаг, худалдааны давуу байдлын төлөө
- Глобалчлалд ялахын төлөө

■ Монгол болон жижиг орнууд

- Үлдэж хоцрохын төлөө
- Хөгжихийн төлөө
- Глобалчлалаас хожихын төлөө



ТӨРӨӨ УРЛАХ ӨРСӨЛДӨӨНӨӨС ЗАЙЛСХИЙХ БИШ,
ИДЭВХТЭЙ ОРОЛЦОХ ХЭРЭГТЭЙ

ЯАЖ? ЯАЖ? ЯАЖ?

Нэг л зүйлийг хатуу ойлгох хэрэгтэй. Төрөө урлах өрсөлдөөн дэлхий даяар болж байна. Монголчууд энэ өрсөлдөөнөөс зайлсхийх бус, өрсөлдөөнд орж хожиж гарах хэрэгтэй юм.

Яаж яаж яаж

МОНГОЛ: ТӨРИЙГ УРЛАХ АСУУДАЛД

Эхлээд бид ямар Төртэй вэ гэдгээ онолын хувьд зөв харах асуудал чухал юм.

РИЙГ ҮЗЭХ ҮЗЭЛ МОНГОЛД 1990 ӨМНӨ, ХОЙНО

Баримтлал (социализм, либерализм)

- 1990 хүртэл
 - Социалист төр - Халамжийн төр
- 1990 оноос хойш
 - Ардчилсан төр - Халамжийн төр

Нэр томъёоны хувьсал (Хүнийсгэл, Өөриймшил)

- “Монголын төр” 1990-2006
- “Монгол төр” 2006 оноос хойш

Нэн орчин үеийн түүхээ эргэн харвал бид Социалист халамжийн төртэй байсан бол одоо Ардчилсан халамжийн төртэй болжээ. Сайн уу муу юу гээд зөндөө харьцуулалт хийж болно.

Нэр томъёоны хувьд дэвшил гарсан шиг санагдаж байна. Ямар ч байсан Монгол төр гэж ярихын цаана өөрсдөө өөрийнхөөрөө боловсронгуй болох ёстой гэсэн санаа нуугдаж байгаа байх.

- Тэтгэвэр, Тэтгэмж
- Хүүхдийн мөнгө
- Алдарт эхийн одонгийн төлбөр
- Гэр бүл болсны тэтгэмж
- Оюутны тэтгэлэг
- Боловсрол, эрүүл мэнд үнэгүй

1990 оноос өмнө Халамжийн төртэй байсан. Өнөөдөр мөн л Халамжийн төртэй байгаа. Асуудлын гол нь халамжаа үзүүлэх эдийн засгийн бололцоогоо бий болгож чадаж байна уу гэдгээр л Төрүүд ялгаатай.

Эдийн засаг хумигдвал Халамж дампуурна. Мөн чанараараа Халамжийн Төр мөн дампуурна.

Халамж хамгийн том улс төр байснаас эдийн засгийн хөгжлийн асуудал хэзээ ч том улс төр байсангүй явж ирлээ. Энэ нь улс төрийн тогтолцоотой холбоотой бөгөөд тэр нь төрийн бодлого популизмд автах нөхцлийг бий болгоод байна.

ХАЛАМЖИЙН ТӨР БА ЧАДАМЖ

ЧАДСАН	ЧАДААГҮЙ
• Социализмд 30 сая хүрч чадахгүй байсан малын тоо 50 сая давсан. • Бүх сум эрчим хүчний шугамд холбогдсон • Бүх аймгийн төвийг засмал замаар холбогдсон	• Зэс хайлуулах үйлдвэр • Төмөрлөгийн үйлдвэр • Газрын тос боловсруулах үйлдвэр • 5 дугаар цахилгаан станц • Нүүрс хийжүүлэх үйлдвэр • Төмөр зам • Сайншанд чөлөөт бүс • Замын Үүдийн чөлөөт бүс

Төр иргэншлийн хэрэгсэл болдог. Энэ талаас нь харвал Монгол төр амжилттай мэт. Сум болгон руу цахилгааны шугам татаад, аймаг болгоныг нийслэлтэй засмал замаар холбоод, сум бүрт суварга босоод, газар бүр тахилгатай уул, овоо бий болоод, 6000 бөх, 4000 морь уралдуулж Гиннесийн номд бүртгэгдээд л.....1000 морин хуурч тоглуулаад лХамгийн том Морин хуур бүтээгээд

Хөгжлийн талаас нь харвал чадамж үлэмж доройтсон харагдаж байна.

ХАЛАМЖИЙН ТӨР



ХӨГЖЛИЙН ТӨР

- Масс нам төвтэй улс төрийн тогтолцоо бий болов
- Популизм сэтгэлгээний хөтөч болов
- Масс нам, төрийн албаны уялдаа, шүтэлцээг зохистой болгох
- Төрийн чадамжийг бий болгох

Төрөө урлах зорилгыг “Халамжийн төрөөс Хөгжлийн төр өөд” гэж томьолбол зүгээр байгаа юм. Төрийг урлах асуудлын цөм нь хөгжил байх хэрэгтэй байгаа юм. Төрд хамаарахгүй асуудал гэж үгүй. Гэвч тэр олон асуудлаас үндсэн асуудалдаа тэргүүн зэргийн ач холбогдол өгөх хэрэгтэй юм.

ТӨРИЙГ УРЛАХУЙ :

ЭВДЭРВЭЛ ХУВЬСГАЛ, ЭВЛЭВЭЛ ХУВЬСАЛ

- ❑ ТӨРИЙН ҮНДСЭН ҮҮРЭГ – ХӨГЖИЛ
- ❑ ХӨТӨЧ БАЙГУУЛЛАГА
 - ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
 - УДИРДЛАГЫН АКАДЕМИ
- ❑ ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ

ELITE AGENCIES

- | | |
|-------------|---|
| • Japan | MITI |
| • Singapore | Ministry of Trade |
| • Korea | Economic Planing Board, Ministry of Finance and the Economy |
| • Taiwan | Council of Economic Planing and Development and the Industrial Structure Bureau in the Ministry of Economic Affairs |
| • Malaysia | Economic Planing Unit in the Prime Minister's cabinet |

Хөтөч байгууллага гэдэгт анхаарал хандуулах хэрэгтэй байна. Азийн орнуудын туршлагаас харвал төрийн олон байгууллагуудаас Elite agencies туршлагыг авч болохоор байгаа юм.

ДҮГНЭЛТ

- Лидерүүдийн төрөө урлах нэгдмэл ойлголт онцгой чухал
- Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд Засгийн газрын Тогтвортой байдал, тэр тусмаа Эдийн засгийн зөв бодлогыг гаргах, хэрэгжүүлэх тогтолцоо чухал

Төрийг урлах асуудлаар Монгол улс дэлхийн өрсөлдөөнд оролцоно гэдэг нь төр нь эдийн засгийн зөв бодлого боловсруулах бүтэцтэй, тэрхүү бодлогоо тогтвортой хэрэгжүүлэх зохион байгуулалттай байх явдал юм.

Анхаарал тавьсанд баярлалаа